



2021 ХАГАС ЖИЛИЙН
ТАЙЛАН

Агуулга

Гүйцэтгэх удирдлагын тайлан	2
Нэгтгэсэн үзүүлэлт	12
Орлогын тайлан	13
Санхүүгийн байдлын тайлан	14
Группын Бүтэц	15
Үнэлгээ	17
Хувьцаа эзэмшигчдийн бүтэц	18
АрдКойны тархалт	19
Арилжааны үзүүлэлт	20
DAX арилжааны үзүүлэлт	21
Хувьцаа эзэмшигчдийн өсөлт	22

Гүйцэтгэх удирдлагын тайлан

Хүндэт хувьцаа эзэмшигч, хамтран зүтгэгч, харилцагчид аа!

Та бүхэндээ 2021 оны эхний хагас жилийн тайлангаа танилцуулж байгаадаа таатай байна.

2021 оны эхний улиралд эдийн засаг сэргэж ДНБ 15.7 хувийн өсөлттэй гарсан боловч вакцинжуулалтын дараах КОВИД-19-ийн тохиолдол огцом нэмэгдсэнээс шалтгаалж II улиралд эдийн засаг эргэн саарав. Түүнчлэн, хил хаасантай холбоотойгоор ложистик болон гадаад худалдааны салбарууд хязгаарлагдаад байна. Засгийн газраас эдийн засгийн эргэлтийг дэмжих бодлогыг баталж, иргэн бүрт мөнгөн тусламж олгосны үр дүнд нь нийт мөнгөний нийлүүлэлт 5 сард 26.7 ихнаяд төгрөгт хүрэв. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 29.5 хувиар өссөн үзүүлэлт юм. Мөн энэ хугацаанд инфляцийн түвшин бараг 2 дахин нэмэгдэж, 2020 оны 5 сард 3.3 хувь байсан бол 2021 оны 5 сард 6.2 хувьд хүрсэн.

2021 оны 5 сарын сүүлээр байгууллага болон хувь хүмүүст олгосон зээлийн нийт дүн 18.3 ихнаяд төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6.2 хувь буюу 1.1 ихнаяд төгрөгөөр нэмэгдсэн юм. Хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн хэмжээ 2 ихнаяд төгрөгт хүрч, жилээр тооцвол 51.8 тэрбум буюу 2.6 хувиар нэмэгджээ.

Монголын хөрөнгийн зах зээлийн нийт үнэлгээ 3.8 ихнаяд төгрөг болж, эхний улирлын 48.5 хувийн огцом өсөлтийн дараа II улиралд харьцангуй тогтвортой байна. Үнэлгээний хувьд тогтворжсон ч нийт арилжаалагдаж буй хөрөнгийн хэмжээ өсөлттэй хэвээр байсан бөгөөд 119.6 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5 дахин их юм. Жилийн эхнээс, Монголын хөрөнгийн зах зээл дээрх хамгийн том ба хамгийн их арилжаалагддаг 20 компанийн нэгтгэсэн зах зээлийн үнэлгээг илтгэдэг ТОП-20 индекс 14,223.21 оноогоор буюу 73.7 хувиар өсөж 33,509 оноонд хүрчээ. Харин MSE A индекс 11.3 хувь, MSE B индекс 53.3 хувиар өссөн байна. Ардын компаниудын арилжааны хэмжээ 93.7 тэрбум төгрөг болж, 2021 оны эхний хагаст Монголын үнэт цаасны зах зээлийг давамгайлан 78.3 хувийг эзэллээ. Товчхондоо, манай нээлттэй хувьцаат компаниуд болон хөрөнгийн зах зээлийн хооронд хүчтэй хамаарал үүсээд байна.

Ардын баг хамт олон хувьцаа эзэмшигчдийнхээ үнэ цэнийг нэмэгдүүлэх, хамгаалахын тулд энэ хүнд хэцүү үед цаг наргүй ажилласаар байгааг дуулгая. Энэ дашрамд нийт ажиллагсдынхаа зориг, сэтгэлд талархал илэрхийлмээр

байна. Би багаараа бахархаж байна, Ардын нэгдмэл баг хамт олон нь Ардыг дийлдэшгүй хүчирхэг болгодог.

Эхний хагаст бид хэд хэдэн чухал ажлын байранд тохирох хүнийг сонгон багтаа нэгтгэсэн. Тухайлбал, Технологи Эрхэлсэн Захирлаар Монгол Контент ХХК-д ажиллаж байсан Э.Баярмагнайг томиллоо. Мөн манай өмнөх Дижитал Технологийн Захирал Г.Тэнүүн багтаа эргэн ирж зөвлөхөөр ажиллаж байна. Харилцагчийн үйлчилгээний төвийг бие даасан хуулийн этгээд болгож, Ц.Солонго удирдан ажиллаж байгаа бол Б.Уянга манай багт нэгдэж хүний нөөцийг удирдан ажиллахаар болов. Ард Кредитын Санхүү Эрхэлсэн Захирлаар Ч.Солонго, Дотоод Аудитороор Б.Оюунбаатарыг багтаа нэмлээ. Харин Аппрентис шоуны ялагч Ц.Бархас Ард Санхүүгийн Нэгдлийн Олон Нийтийн Харилцаа, Маркетинг Эрхэлсэн Захирал болон Ард Холдингс Интернэшнл компанийн Гүйцэтгэх Захирлаар тус тус ажиллаж байна. Ийнхүү бид 2021 оны эхний хагаст нийт 132 шинэ ажилтанг багтаа нэгтгэжээ.

2021 оны эхний хагаст бид компанийн хувьцаагаа АрдКойны урамшуулалтайгаар олон нийт, стратегийн хөрөнгө оруулагчдад санал болгох замаар 5 удаа олон нийтээс хөрөнгө босгохдоо нийт 22.6 сая АрдКойныг тараасан байна. Ингээд нийт 14,371 хөрөнгө оруулагч 12 тэрбум төгрөгөөр Ардтай холбоотой хувьцаа авав. Харин стратегийн хөрөнгө оруулагчид 15 тэрбум төгрөгөөр Ардын хувьцаа болон АрдКойн авчээ. Үүний үр дүнд, AARD-ын 15 хувь, AIC, ADB-ын 20 хувь, ХОС-ын 3.5 хувийг арилжсан байна.

Ард Холдингсын баг хэд хэдэн томоохон шинэ гэрээ хэлэлцээрийг гүйцэтгэж, ТУЗ тухай бүрт нь батлан ажиллаж байна. Хэлэлцээрүүд маань амжилттай хийгдэж байгааг дуулгахад таатай байна.

- Хамгийн анхны нээлттэй медиа групп компани болох ТэнГэрЛиг Медиа группыг бид 7 сарын 1-нд олон нийтэд танилцууллаа. Тус Группын бүрэлдэхүүнд 10 гаруй компанийн 2 нь ТВ суваг, орчин үеийн дэвшилтэт технологи бүхий байгуулах студи, цахим мэдээллийн суваг гэх мэт байгаа болно.
- 4 жил орчим хэлэлцээр өрнүүлсний эцэст ГрэйпСити Монгол болон МОСТ Финтек компаниуд манай эгнээнд нэгдлээ. Ард Санхүүгийн Нэгдэл Монголын Үнэт Цаасны Биржийг мөн эгнээндээ нэгтгэсэн бөгөөд Улаанбаатарын Үнэт Цаасны Бирж буюу UBX нэршил бүхий ребрэндингийн ажил ид дундаа явж байна.

Ард Секюритиз ҮЦК 1 сард Степ Голд компанийн IPO-г хийх эрх авсан ба 6 сарын сүүлээр СЗХ-ноос зөвшөөрөл олгосон юм. Бид тус компанийн удирдлагын багтай зөвшилцөж, олон нийтэд удахгүй хувьцааг нь санал болгох болно. Мөн тус компанийн хувьцаа Канад болон Монголын хөрөнгийн биржүүдийн хооронд чөлөөтэй хөрвөдөг болсныг дуулгахад таатай байна.

Бид Богд Банкны удирдлагуудтай хамтран ажиллаж, IPO-ны өмнөх хөрөнгө оруулалт хийхээр Ард Холдингс Интернэшнлын хүсэлтээ Монголбанкинд хүргүүлсэн. Мөн тус банкныг IPO хийх ажлын хүрээнд баримт бичгүүдээ Санхүүгийн Зохицуулах Хороо, Монголбанкинд 6 сарын сүүлээр хүргүүлээд байна. Бид зохицуулагч байгууллагуудын хариуг хүлээж байна.

Монголын Хөрөнгийн Биржийн хоёрдогч зах зээлийн арилжааны нийт дүн энэ оны эхний 5 сард 225 тэрбум төгрөг байсан бөгөөд үүнээс Ард Секюритиз дангаараа 162.7 тэрбум төгрөгийн арилжаа буюу нийт зах зээлийн 72.3 хувийг зуучилжээ.

Ард Даатгал цар тахлын нөхцөл байдалд ч үйл ажиллагаагаа өргөжүүлсээр, хувьцаа эзэмшигчдийн тоо 5 дахин нугарч 10 мянгад хүрэв. Харин хувьцааны ханш нь (MSE: AIC) түүхэн дээд хэмжээгээ давж 1,800 төгрөг болоод байна. Мөн АрдМэнд 360 эрүүл мэндийн даатгал, COVID-19 даатгал зэрэг даатгалын шинэ бүтээгдэхүүнийг зах зээлд амжилттай нэвтрүүлээ. Ард Даатгал Асралт Мед эмнэлэгтэй хамтран Ардын бүх ажиллагсад, тэдний гэр бүлийнхэн болон харилцагч нараа халамжлах ажлын хүрээнд COVID-19-өөс хамгаалах Спутник вакцинд хамруулж чадлаа.

Түүнчлэн Ард Даатгал нь харилцагчдад нөхөн төлбөрийн хүсэлтээ онлайнаар ирүүлэх боломжийг олгож, үйл ажиллагаагаа цахимжуулах чиглэлээр багагүй ажил хийгээд байна. Тайлант хугацаанд тус компанийн цэвэр ашиг 6.6 тэрбум төгрөгт хүрсэн бол нийт хөрөнгийн хэмжээ 5.5 тэрбум төгрөгөөр нэмэгдэж 34.3 тэрбум төгрөг болов. Тэд 2020 оны үр дүндээ тулгуурлан 1 тэрбум төгрөгийн ногдол ашгийг хувьцаа эзэмшигчдэдээ тараасан.

Ард Кредитын хувьд нэгэн түүхэн үйл явдал болсон нь 3 сарын 22-нд 10 жилийн ойгоо угтсан явдал юм. Нийгмийн бүхий л хэсэгт цар тахлын дэгдэлт их байсан хэдий ч Ард Кредитын хувьцааны үнэ (MSE: ADB) түүхэн дээд хэмжээгээ давж 351 төгрөгт хүрсэн ба хувьцаа эзэмшигчдийн тоо 6 дахин нэмэгдэж 13.6 мянга боллоо. Өмнөх жилийн цэвэр ашгийн 50 хувь буюу 1 тэрбум төгрөгийг 10.3 мянган хувьцаа эзэмшигчдэдээ 6 сард багтаан тараасан. Эхний хагаст баланс нь 2 дахин өсөж 69.3 тэрбум төгрөгт хүрсэн бол нийт зээлийн багц 30.3 тэрбум

төгрөгт хүрсэн үзүүлэлттэй байна. Татварын дараах байдлаар 4.7 тэрбум төгрөгийн ашиг олсон бөгөөд нийт дэлгэрэнгүй орлогын хэмжээ 19.7 тэрбум төгрөгт хүрсэн нь итгэмээргүй өсөлттэй тоо билээ.

Ард Лайф ч мөн зах зээл дэхь байр сууриа нэмэгдүүлэн одоогоор 47 мянга гаруй идэвхтэй тэтгэврийн хуримтлалын данс эзэмшигчдэд үйлчилж байгаа ба жилийн эцэс гэхэд 100 мянган харилцагчтай болох зорилгоо биелүүлэх нь тодорхой боллоо. Мөн Ард Лайфын 5 хувийг стратегийн хөрөнгө оруулагч худалдан авсан.

Ард Актив улсын шилдэг хадгаламж зээлийн хоршоо болох замаа засаж, 2021 оны эхний хагас гэхэд гишүүдийнхээ тоог 2 дахин нэмэгдүүлж 2,788-д хүргэсэн бол нийт хөрөнгийн хэмжээ 177 хувиар өсөж 19 тэрбум төгрөг, нийт хадгаламжийн хэмжээ 158 хувиар өсөж 14 тэрбум төгрөг боллоо. Ард Активын хувьд гайхмаар өсөлтөөс гадна зээлийн багцын чанарыг харууллаа. Жилийн эхнээс 162 хувийн өсөлт үзүүлсэн бөгөөд нийт зээлийн багцын хэмжээ 13.8 тэрбум төгрөгт хүрснээс 99.7 хувийг хэвийн зээл эзэлж байна.

2021 оны II улиралд Ард Лизинг компани үйл ажиллагаагаа эхлүүлж, Ард Кредит ХК-ийн Үйл Ажиллагаа Эрхэлсэн Захирлаар ажиллаж байсан Г.Сүхбаатарыг тус компанийн Гүйцэтгэх Захирлаар томилов. Тухайн компанийн хөрөнгө маш хурдацтай 16.3 тэрбум төгрөг болж өсөөд байгаа юм.

Ард Пропертиз ХХК нь Ардын оффисуудыг хариуцахаас гадна Санкт Морьт дахь үл хөдлөх хөрөнгийг удирдаж байна. Ардын хүний нөөцийн тэлэлтэд Өнгөт хэвлэл дэхь оффисын орон зай хүрэлцэхгүй болсон бөгөөд бид Сэнтрал Тауэр руу нүүдэл хийн өргөжиж байна.

Булган Ундрага ХК-ийн (MSE: BUN) хувьцаа эргээд Монголын Хөрөнгийн Бирж дээр арилжаалагдаж эхэлсэн бөгөөд жилийн эхэнд 875 төгрөг байсан бол одоо 160 мянган төгрөгөөр арилжаалагдаж байна.

Үндэсний Хувьчлалын Сангийн цэвэр хөрөнгийн үнэлгээ 5.25 тэрбум төгрөгөөс 7.75 тэрбум төгрөг болж өссөн нь жилийн эхнээс 47.8 хувийн өсөлт үзүүлэв. Үндэсний Хувьчлалын Сан буюу ХОС-ийн нэгж эрх нь Монголын Хөрөнгийн Бирж дээр хамгийн идэвхтэй арилжаалагдсан үнэт цаасны 1 болж, ханш нь 4 сард оргилдоо хүрч, түүхэн дээд ханш болох 653.89 төгрөгт хүрлээ. Үүний дараа 250 орчим төгрөгт тогтворжоод байна. Нэгж эрх эзэмшигчдийн тоо 150 хувиар өсөж 6,382 болоод байгаа билээ.

DAX бирж Ард Кредитын Гүйцэтгэх Захирал асан Ч.Ганзоригийн удирдлага дор гайхалтай амжилтаа үргэлжлүүлсээр 4 сард шилдэг залуу мэргэжилтнүүдээс

бүрдсэн мэдээлэл технологийн багийг эгнээндээ нэгтгэсэн. DAX нь жилийн эхнээс 4.2 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж, нийт 9 хослолоор 6 төрлийн хөрөнгийн 1.02 их наяд төгрөгийн арилжааг биржээрээ дамжуулан хийжээ. Уг Цахим Хөрөнгийн Бирж нь арилжааны үйлчилгээ үзүүлэхээс гадна 400 мянга гаруй бүртгэлтэй хэрэглэгчийнхээ 109 тэрбум төгрөгийг хянах кастодианы үйлчилгээг мөн үзүүлж байна. Биржийн үндсэн хөрөнгө болох АрдКойн нь хамгийн идэвхтэй арилжаалагддаг хөрөнгө юм. Хамгийн идэвхтэй арилжаалагдсан хослол ARDX/MNT нь биржийн нийт арилжааны дүнгийн 89 хувийг эзэлсэн бөгөөд уг хослолын өдрийн дундаж арилжааны дүн 5 тэрбум төгрөг байв. I улиралд гайхалтай өсөлт үзүүлсэн АрдКойны ханш 5 төгрөгөөс 200 орчим төгрөг дээр тогтворжсон бол II улиралд АрдКойны ханш 180 төгрөгөөс 220 төгрөгийн хооронд хэлбэлзсэн бөгөөд багадаа 145, ихдээ 475 төгрөгт хүрсэн байна.

Бид DAX биржийн шинэ хувилбарыг 7 сард танилцууллаа. Шинэчлэлтийн хүрээнд олон улсын харилцагчид уг биржид бүртгүүлж, дэлхийн өнцөг булан бүрээс арилжаанд оролцох боломжтой болж байгаа юм. DAX нь Монголын Үнэт Цаасны Биржид (UBX болгож ребрэндинг хийх ажил явагдаж байна) хөрөнгө оруулаад байгаа бол Ард Холдингс толгой компанид нь удирдлагын байр суурь эзлээд байна. Монголын Үнэт Цаасны Биржийн Гүйцэтгэх Захирлаар Ард Секюритизыг удирдан ажиллаж байсан Ж.Золзаяа 5 сард томилогдсон билээ.

4 сарын 30-нд АрдКойн Bittrex Global бирж дээр гарч, одоогоор USDT, ETH, BTC гэх хослолуудаар арилжаалагдаж байна. Үүний дараа 6 сарын 18-нд АрдКойн нь дэлхийн хамгийн том төвлөрсөн бирж болох UniSwap дээр USDT, ETH гэх хослолуудаар арилжаалагддаг болов. АрдКойныг техникийн хувьд хөгжүүлэх ажлууд үргэлжилсээр. Тухайлбал, АрдКойныг Ethereum блокчэйнээс BinanceSmartChain рүү амжилттай зөөвөрлөж, 7 сарын сүүл гэхэд АрдКойныг бас нэгэн төвлөрсөн бирж болох PanCakeSwap дээр гаргахаар ажилллаж байна.

Бид ArdMoney-г (ARDM, BinanceSmartChain BEP-20 protocol token) албан ёсоор зарласан бөгөөд энэ нь DAX биржийн үндсэн токен болох юм. Нээлтийн урамшуулал болгож АрдКойн эзэмшигчдэдээ 7 сарын 1-нээс 7 сарын 25-ны хооронд DAX-аар дамжуулан ArdMoney олголоо. ArdMoney-ын үндсэн зорилго нь АрдКойны үнэ цэнийг нэмэгдүүлэхэд чиглэнэ. Цаашдаа ArdMoney аажмаар АрдКойныг орлож, Ард Санхүүгийн Нэгдлийн урамшууллын токен болох ба бүрэн автоматжсан блокчэйнээр үүсгэх боломжтой. ArdMoney нь АрдКойноор бүрэн баталгаажсан байх бөгөөд АрдКойн ирээдүйд Биткойны Монгол хувилбар болох юм.

АрдШоп бүртгэлтэй харилцагчдынхаа тоог 760 мянга болгож, цар хүрээгээ тэлсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт барааны хэмжээ 4 дахин өссөн үзүүлэлт юм. Түүнчлэн Ард Холдингс АрдШопын захиалгын технологийг ашиглан Хөрөнгө Оруулалтын гуравдугаар аяны хүрээнд олон нийтээс амжилттай хөрөнгө татан төвлөрүүлж чадсан билээ. АрдШоп Ард Апп дээр дуудлага худалдааны функцыг амжилттай нэвтрүүлсэн бөгөөд Ардын хамт олон дунд Монголын анхны NFT дуудлага худалдааг амжилттай зохион байгуулав. Үүний зэрэгцээ АрдШоп нь Ард Апп дахь тоглоомын функцын технологийн шийдлийг боловсруулаад байна. Цахим худалдааны дэлгүүрийн хувьд оновчтой гүйлгээний урсгалыг Most Money болон GrapeCity Mongolia компаниудтай хамтран амжилттай хэрэгжүүлэв. Одоогоор АрдШоп 2021 он дуустал маркетингийн хүчин чадлаа сайжруулахаас илүүтэй худалдагчийн бүртгэлийн үйл явцыг бүрэн автоматжуулахад анхаарлаа төвлөрүүлж байна.

Бид компанийн хувьцаагаа Канадад гаргахаар өндөр чадамжтай, авьяаслаг баг бүрэлдэхүүн бүхий M&C Consulting компанитай хамтран ажиллаж эхлээд багагүй хугацаа өнгөрсөн. Тэд олон улсын том байгууллагууд, Засгийн газрууд, ТББ-уудтай хамтран ажилладаг бөгөөд Канад, АНУ-д нэр хүндтэй болж, өөрсдийн орон зайг олж чадсан. Ардыг гадаадын зах зээл дээр хувьцаагаа бүртгүүлэх уул уурхайн бус салбарын анхны Монгол компани болгох зорилго тавьж, 4 сараас эхлэн манай багууд өдөр шөнөгүй ажилласаар. Хамтын ажиллагаа эхэлснээс хойш бид анхан шатны зах зээлийн судалгаагаа хийж дуусгасан бөгөөд Торонтогийн Хөрөнгийн Бирж дээр амжилттай IPO хийх сууриа тавьж, 2021 ондоо багтаан хувьцаагаа бүртгүүлэхээр ажиллаж байгаагаа хэлэхэд таатай байна.

Аль болох багаасаа хөрөнгө оруулж эхлэхийн чухлыг Ард хэзээд зааж чиглүүлсээр ирсэн. Энэ жил бид Хувьцаатай Хүүхэд хөтөлбөрөөрөө дамжуулан 999 хувьцаа эзэмшигч хүүхдүүдийг нэгтгэлээ. Уг хөтөлбөр нь хүүхдийнхээ ирээдүйд хөрөнгө оруулах хүсэлтэй эцэг эхчүүдэд сонголт хийхэд илүү хялбар болгож өгсөн юм. Мөн Хүүхэд бүрт 77 АрдКойн хөтөлбөрийнхөө бүргэлийг 7 сарын 7 хүртэл сунгаж, анх зарласан бүртгэлийн өдөр буюу 5 сарын 1-нээс өмнө бүртгүүлсэн хүүхэд бүр 100 АрдКойн, харин түүнээс хойш бүртгүүлсэн хүүхэд бүр 77 АрдКойны урамшуулал хүртэхээр болгон дүрмээ шинэчилсэн, одоогоор 200,000 гаруй хүүхэд уг хөтөлбөрт бүртгүүлээд байна.

6 сарын 8-нд Монгол орон даяар, 21 аймаг 330 сумдад санхүүгийн боловсролыг хүртээмжтэй түгээх Илгээлтийн Эзэд төслийг эхлүүлэв. Энэхүү төслийн хүрээнд оюутан залуус цалинтай дадлага хийхийн зэрэгцээ өөрийн төрөлх нутагтаа санхүүгийн боловсролыг нэмэгдүүлэх 30 өдрийн 30 даалгавар биелүүлэн

өрсөлдөж, алс суугаа иргэдэд Ардын бүтээгдэхүүн үйлчилгээг танилцуулах үүрэгтэй юм. Илгээлтийн Эздийг бүс нутагт нь хуваарилахын өмнө сайтар бэлтгэн сургаж, хөтөлбөрийн бүхий л шатанд Ардын дэмжлэг үзүүлэх багаас оролцогчдыг дэмжсээр байна. Хөтөлбөрт оролцогчдыг 250 сая төгрөгийн шагналын сангаас гадна ур чадвар, авхаалж самбаагаараа шалгарсан шилдгүүдэд Ардад ажиллах боломж нээгдэх юм.

2021 оны II улиралд бид нийгмийн хариуцлагын ажлуудаа үргэлжлүүлж, юун түрүүнд цар тахлын эсрэг тэмцэж, хамгийн эрсдэлтэй бүсэд ажиллаж буй 100 сувилагчид 100 сая төгрөгийг хуваарилж, тус бүрт 1 сая төгрөг олгосон. Мөн санхүүгийн үйлчилгээг хүртээмжтэй болгох замаар эмэгтэйчүүдийн эдийн засгийн чадамжийг нэмэгдүүлэх зорилготой төрийн бус байгууллага - Эмэгтэйчүүдийн Дэлхийн Банктай хамтран ажиллаж эхлээд байна. Хамтын ажиллагааны хүрээнд тус байгууллагаас уламжлал болгон зохион байгуулдаг хамгийн том арга хэмжээ болох Санхүүг эмэгтэйчүүдийн төлөө ажиллуулах арга хэмжээний спонсороор ажиллахаар боллоо. Энэ дашрамд, манайхаас нийгмийн хариуцлагын хүрээнд нээгдэж буй томоохон ажил болох ХАСҮ буюу Хүчирхэг Ардын Сан ТББ, Монголын хамгийн том ТББ-ыг зарлаж буйдаа таатай байна. Сангийн үйл ажиллагаа нь санхүүгийн боловсрол, шинэ технологи инноваци, ногоон хөгжил, байгаль орчин, хүүхэд, урлаг, спортын чиглэлийн төсөл санаачилгуудыг дэмжин ажиллах юм.

12 сард Ард Апп 4 дэхь хувилбараа танилцуулж, бүртгэл, баталгаажуулалтаа бүрэн цахимаар хийх боломжуудыг хэрэглэгчдэд олгосноос гадна Монголбанкнаас тавьсан шаардлагын дагуу харилцагчийн баталгаажуулалтын функцыг Аппдаа бүрэн нэвтрүүлээд байна. Засгийн газрын ХУР системтэй шууд холбогдсоноор харилцагчдад хурууны хээгээрээ дамжуулан баталгаажуулалт хийх, паспортын баталгаажуулалтыг ч мөн автоматаар хийх, өөрийн биеэр ирэлгүйгээр өдрийн гүйлгээний лимитээ өсгөх бололцоог олгосон юм. Монгол Шуудангийн хамтын ажиллагаагаар дамжуулан харилцагчийн зээлийн гэрээ шууд гэрийн хаягаар нь хүргэгдэж байгаа нь халдвар хамгааллын дэглэм баримтлах шаардлагатай энэ үед харилцагч, байгууллага аль аль талдаа давуу талтай байна.

Ард Аппад итгэлцлийн үйлчилгээ, хадгаламж, автомашин, АрдКойн барьцаалсан зээлийн үйлчилгээнүүд нэвтрээд байна. 4 сарын 1-нд Монголбанкны шаардлагын дагуу Апп доторх АрдКойн шилжүүлгийн функцыг хязгаарлах хэрэгтэй болсон. DAX-ын шинэ вэб хувилбарт АрдКойноо хадгалаад арвижуулах HODL функцыг нэмсэн бөгөөд зохицуулагч байгууллагуудын шаардлагын дагуу виртуал хөрөнгийн тусдаа хэтэвч нээхээр төлөвлөн ажиллаж байна. Ард

Секюритиз Монголын Хөрөнгийн Бирж дээр шууд доллар болон төгрөгийн бондын арилжаанд оролцох функцыг нэвтрүүлснээс гадна эцэг эх нь хүүхдийнхээ хувьцааны дансыг удирдах боломжийг нээгээд байгаа юм. III улиралд багтан UBХ биржийг Ард Апптай интеграцилах төслийг эхлүүлж, банкны үндсэн систем болон Ард Аппын дэд бүтцээ сайжруулан, аюулгүй байдлын нэмэлт системүүдийг тун удалгүй нэврүүлэхээр ажиллаж байна.

2021 оны эхний хагас жил нь Ардын хувьд түүхэн өсөлтийн цаг үе байлаа. Зах зээл дэхь давуу байр сууриа ашиглан бид хэд хэдэн томоохон хэлэлцээр, худалдан авалтыг хийж үйл ажиллагааны цар хүрээгээ тэллээ. Түүнчлэн, оны сүүлийн хагаст шинэ бизнесүүдээ нэгтгэн, технологиудаа интеграцилж бүгдийг нэг дор багтаасан супер аппаараа харилцагчдадаа хамгийн сайн нэгдсэн үйлчилгээ олгохоор зорьж байна.

Хүчтэй. Хамтдаа.

Гүнээ хүндэтгэж, мэхийн ёсолсон,
Ард Санхүүгийн Нэгдлийн Үүсгэн Байгуулагч, танай Гүйцэтгэх Захирал
Хутагт овогтой Чулууны Ганхуяг

Нэгтгэсэн үзүүлэлт

	2020	2021 У1	2021 У2
Нийт компани	20	21	33
Нийт ажиллагсад	223	276	297
Хувьцаа эзэмшигч	12,296	57,940	58,463
Ард Алп хэрэглэгч	637,000	1,189,000	1,261,382
АрдКойн эзэмшигч	286,117	668,312	514,919
Зээлдэгч	37,694	39,000	40,947
Даатгуулагч	166,509	226,394	206,871
Тэтгэврийн данс эзэмшигч	10,500	25,570	46,569
Үнэт цаасны данс эзэмшигч	89,305	117,000	122,558

*Хувьцаа эзэмшигчдийн тоонд Монгол Шуудан ХК-ийн хувьцаа эзэмшигчид болон DAX дээр ARDT токен эзэмшигчид багтсан болно.

Орлогын тайлан


(мянган төгрөг)	2020 У2	2020	2021 У2	Жилийн өөрчлөлт
Хөрөнгө оруулалтын орлого	1,794,383	303,915	8,429,306	4.7х
Хүүгийн орлого	30,862	30,984	937,644	30.4х
Ногдол ашгийн орлого	1,346,630	1,311,736	964,580	-28.4%
Түрээсийн орлого	383,155	770,464	240,364	-37.3%
Менежментийн орлого	368,776	688,461	872,661	2.4х
НИЙТ ОРЛОГО	3,923,806	3,105,560	11,444,553	2.9х
Цалингийн зардал	886,441	1,551,948	927,037	4.6%
Үйл ажиллагааны зардал	1,146,236	2,676,280	3,387,802	3.0х
Санхүүгийн зардал	890,936	2,889,184	1,496,503	68.0%
НИЙТ ЗАРДАЛ	2,923,613	7,117,412	5,811,341	98.8%
Бусад олз (гарз)	37,279	145,276	(322,717)	-965.7%
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(125,648)	(170,140)	(1,118)	-99.1%
ТАТВАРЫН ӨМНӨХ АШИГ	911,824	(4,036,716)	5,309,377	5.8х
Орлогын албан татварын зардал	134,666	(2,041)	678,910	5.0х
ЦЭВЭР АШИГ	777,158	(4,034,675)	4,630,467	6.0х
Хөрөнгө оруулалтын үнэлгээний олз (гарз)	(5,535,094)	4,235,021	317,817,325	59х
НИЙТ ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГО	(4,757,936)	200,346	322,447,792	69х


Санхүүгийн байдлын тайлан

(сая төгрөг)	2020У2	2020	2021У2	Жилийн өөрчлөлт
Бэлэн мөнгө	185,354	100,958	35,110	-81.1%
Авлага	7,107,150	1,687,455	19,151,117	2.7x
Урьдчилж төлсөн төлбөр	3,760,496	0		-100.0%
Бусдад олгосон зээл	0	1,243,564	4,016,923	
Үндсэн хөрөнгө	1,290,608	906,458	380,464	-70.5%
Биет бус хөрөнгө	117,992	8,941,367	173,607,508	1471.3x
Богино хугацаат хөрөнгө оруулалт	16,994	18,737	19,160	12.7%
Урт хугацаат хөрөнгө оруулалт	60,828,970	67,481,313	254,647,905	4.2x
НИЙТ ХӨРӨНГӨ	73,307,564	80,379,852	451,858,186	6.2x
Өглөг	672,859	4,902,078	7,044,659	10.5x
Богино хугацаат өр төлбөр	1,519,311	11,958,106	10,657,433	7.0x
Банкны зээл	2,082,372	1,147,287	5,062,527	2.4x
Урт хугацаат өр төлбөр	16,257,047	3,135,077	2,235,006	-86.3%
Хойшлогдсон татварын өр	1,951,649	3,405,208	44,237,852	22.7x
НИЙТ ӨР ТӨЛБӨР	22,483,238	24,547,756	69,237,478	3.1x
Энгийн хувьцаа	27,175,629	27,175,629	28,614,263	5.3%
Нэмж төлөгдсөн капитал	0		2,927,696	x
Дахин үнэлгээний нөөц	10,589,419	27,284,096	345,101,421	32.6x
Бусад эздийн өмч	13,799	13,799	13,799	0.0%
Хуримтлагдсан ашиг	13,045,479	1,358,572	5,963,528	-54.3%
ЭЗДИЙН ӨМЧ	50,824,326	55,832,096	382,620,708	7.5x

Группын Бүтэц

Санхүү





* UBХ-ын толгой компани болох Даац Хөрөнгө Оруулалт дахь Ард Санхүүгийн Нэгдлийн эзэмшлийг UBХ-ын эзэмшил болгон харуулсан болно.

Үнэлгээ

(мян. төгрөг)	2020	Эзэмшил %	2021 У1	Эзэмшил %	2021 У2	Эзэмшил %
Стратегийн хөрөнгө оруулалт	67,449,342		244,675,970		329,568,528	
Монгол Шуудан ХК (MSE: MNP)	17,688,890	23.68%	39,965,102	23.69%	28,180,511	23.64%
Ард Даатгал ХК (MSE: AIC)	13,108,084	65.54%	18,334,734	50.40%	16,523,180	45.49%
Ард Кредит ХК (MSE: ADB)	14,080,132	61.25%	32,242,967	46.02%	28,408,411	40.58%
Ард Секюритиз	2,304,926	100.00%	19,489,426	100.00%	19,125,758	100.00%
Ард Менежмент	1,265,333	100.00%	10,859,383	100.00%	12,271,179	100.00%
Ард Актив	98,726	9.50%	319,108	9.46%	415,268	9.45%
Ард Лайф	11,426,041	100.00%	51,008,848	100.00%	46,048,185	95.00%
Ард Бит			38,922,560	100.00%	111,973,762	100.00%
Ард Лизинг			8,767,792	100.00%	10,173,345	100.00%
Тэнгэр Системс	1,153,508	100.00%	7,502,430	100.00%	9,635,791	100.00%
Ард Холдингс Интернэшнл	6,323,702	100.00%	17,263,620	100.00%	13,192,607	100.00%
Ард Пропертис					33,620,531	100.00%
Тактикийн хөрөнгө оруулалт	49,708		23,254,768		26,486,147	
Үндэсний Хувьчлалын Сан (MSE: ХОС)	2,639	0.05%	4,346	0.03%	0	0.00%
Булган Ундрага ХК (MSE: BUN)	28,332	32.89%	229,585	32.89%	5,666,987	29.78%
Бусад санхүүгийн хэрэгсэл	18,737		23,020,837		20,819,160	
Бусад	-8,262,746		140,281,199		117,075,509	
Үндсэн ба биет бус хөрөнгө	9,407,392		149,971,940		118,820,472	
Бэлэн мөнгө	100,958		615,995		35,110	
Бусад цэвэр хөрөнгө	-17,771,096		(10,306,736)		(1,780,073)	
Нийт үнэлгээ	59,236,304		408,211,937		473,130,184	
Эргэлтэд буй хувьцаа	27,175,629		28,614,263		28,614,263	

Нэгж хувьцааны үнэлгээ	2,180	14,266	16,535
-----------------------------------	--------------	---------------	---------------

Хувьцаа эзэмшигчдийн бүтэц

(2021 оны 6 сарын 30-ны байдлаар)


#	Хувьцаа эзэмшигч	2020 У4	2021 У1	Улирлын өөрчлөлт		2021 У2	Эзэмшил
1	И Ай Ти	733,349	4,547,305	39,668	0.14%	4,586,973	16.03%
2	Ард Лайф	1,565,288	1,842,279	297,715	1.04%	2,139,994	7.48%
3	Бруно Рашле	2,098,592	2,104,592	0	0.00%	2,104,592	7.36%
4	Авир Сүхдорж	563,155	568,266	1,350,000	4.72%	1,918,266	6.70%
5	Ард Холдингс Интернэшнл	2,874,410	1,300,000	299,616	1.05%	1,599,616	5.59%
6	Хишигдорж Батхишиг	2,657,214	2,658,444	-1,145,834	-4.00%	1,512,610	5.29%
7	Хутагт овогтой Чулууны Ганхуяг	1,264,519	1,340,364	9,149	0.03%	1,349,513	4.72%
8	Галням Уянга	1,333,147	1,346,936	0	0.00%	1,346,936	4.71%
9	Ард Секюритиз	1,033,080	761,126	315,190	1.10%	1,076,316	3.76%
10	DAX (ARDT 8,000 гаруй хүн эзэмшдэг)	1,000,000	1,000,000	-108,431	-0.38%	891,569	3.12%
11	Нармандах Мөнхнасан	0	344,311	259,090	0.91%	603,401	2.11%
12	Ронок Лимитед	479,111	479,111	0	0.00%	479,111	1.67%
13	Сэдбазар Гэрэлтуяа	455,717	455,935	0	0.00%	455,935	1.59%
14	Ард Даатгал	417,905	411,455	0	0.00%	411,455	1.44%
15	Ганхуяг Бат-Эрдэнэ	0	352,097	0	0.00%	352,097	1.23%
Топ 15 хувьцаа эзэмшигч						20,828,384	72.79%
Бусад хувьцаа эзэмшигчид						7,785,879	27.21%
Эргэлтэд байгаа хувьцаа						28,614,263	100%
Хувьцаа эзэмшигчдийн тоо						17,520	
ARDT эзэмшигчдийн тоо						7,673	

АрдКойны тархалт

№	Тархалт	2020		2021 У2	
		Дүн	%	Дүн	%
1	Компаниуд	2,779,532,630	53.9%	1,983,364,682	38.45%
2	Хэрэглэгчид	1,827,954,131	35.4%	2,042,843,545	39.60%
3	Нөөц (Ард Бит)	442,047,526.79	8.6%	580,236,379	11.25%
4	Бирж (Dax.mn, trade.mn, stex.com, bittrex.com)	108,768,713	2.1%	551,863,394	10.70%
Нийт		5,158,308,000	100%	5,158,308,000	100%

Арилжааны үзүүлэлт

Хувьцааны арилжаа - AARD



Зах зээлийн үнэлгээ

	(тэрбум төгрөг)
Нийт зах зээлийн үнэлгээ	3,804.04
Хувьцааны арилжааны дүн	119.6

Индексүүд

	Нээлт	Хаалт	Өөрчлөлт
TOP-20	19,285.80	33,509.01	73.7%
MSE-A	9,122.01	10,404.05	14.1%
MSE-B	7,581.13	11,242.27	48.3%

Тикер	Үнэт цаас	ДЭЭД	ДООД	НЭЭЛТ	ХААЛТ	ӨӨРЧЛӨЛТ	ҮНИЙН ДҮН	%
AARD	Ард Санхүүгийн Нэгдэл	13,000	1,600	1,758	9,385	433.8%	59,042,319,408	49.4%
AIC	Ард Даатгал	1,800	705	800	1,453	81.6%	10,314,273,734	8.6%
ADB	Ард Кредит	360	76	82	250	204.9%	18,077,045,501	15.1%
MNP	Монгол шуудан	1,999	600	750	1,197	59.6%	701,599,786	0.6%
XOC	Үндэсний Хөрөнгө Оруулаг	750	106.5	109	265	142.7%	5,520,450,613	4.6%
BUN	Булган Ундрага	230,000	874.92	760.8	168,100	21995.2%	2,081,333,736	1.7%

НИЙТ ҮНИЙН ДҮН 95,737,022,778 80.1%

МХБ-ийн нийт арилжааний үнийн дүн 119,551,384,349 100%

DAX арилжааны үзүүлэлт

Хөрөнгө	Нийт арилжааны дүн	Өдрийн дундаж арилжааны дүн	Нээлтийн ханш	Хаалтын ханш	Дундаж ханш
ARDT	17,946,093	116,533	3,198	9,211	8,659
ARDX	6,295,670,760	34,975,948	5.18	217	190
BTC	783	4.35	74,700,000	100,000,000	150,743,835
ETH	3,915	67.49	8,900,000	6,001,000	8,619,403
USDT	2,114,627	36,960	2,900	2,949	3,234
MNT	1,288,429,160,345	7,157,939,780	1	1	1

Хувьцаа эзэмшигчдийн өсөлт

